



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Зоонозын халдварт өвчний долоо хоног тутмын мэдээлэл

Дугаар №08


2019 оны 3-р сарын 11-15

НЭГ. ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН МЭДЭЭ


Улсын хэмжээнд 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй байж болзошгүй нийт 51 яаралтай дуудлагыг хүлээн авсан байна. Эдгээрийн 40(78.4) галзуугийн эрсдэлд өртсөн, 6(11.7%) хачигт халдвар, 2(3.9%) хумхаа, 1(2%) ям, 1(2%) денги, 1(2%) бэтэг өвчний сэжигтэй тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

1.1. Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол:

Булган, Говь-Алтай, Дорноговь, Дундговь, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хэнтий, Завхан аймгийн 15 сум, нийслэлийн 3 дүүргээс галзуу өвчний эрсдэлд өртсөн нийт 40 тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 21%-иар их байна. Эпидемиологийн 9-р долоо хоногтой харьцуулахад 2 тохиолдлоор бага үзүүлэлттэй байна.



Галзуу өвчний сэжигтэй зэрлэг, мал амьтанд уруулж, ноцуулан, шүлсдүүлсэн хүмүүсийн тохиолдлыг эх уурхайгаар нь авч үзвэл: чононд (30.0%) эзэнтэй нохойд (22.5%), үнэгэнд (17.5%), эзэнгүй нохойд (17.5%), мануулд (7.5%), тэмээнд (2.5%) нь уруулсан байна.



Энэ долоо хоногт Ховд аймгийн Зэрэг сумаас галзуу өвчний эрсдэлд өртсөн 1 тохиолдол бүртгэгдсэн. Эрсдэлд өртсөн тохиолдол эмнэлэгт хандаж галзуугийн эсрэг вакцины эхний тунд хамрагдсан байна. Нохойг (эзэнтэй) уяж хяналтад авсан.

1.2 Хачгаар дамжих халдварт өвчний сэжигтэй тохиолдол:

Баянхонгор, Булган, Говьсүмбэр аймгийн 3 сум, нийслэлийн 2 дүүрэгт хачгаар дамжих халдварын 6 сэжигтэй тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 45.4%-иар буурсан байна. Эпидемиологийн 9-р долоо хоногтой харьцуулахад адил үзүүлэлттэй байна.



Энэ долоо хоногт Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумаас хачигт риккетсиозын 1 сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн. 47 настай, эмэгтэй. 2019 оны 3-р сарын 01-нд Сүмбэр сумын VI-р багийн “Баянбулаг” гэдэг газар очиж хонины гэдэс арилгасан. 3-р сарын 09-нд баруун чихний дээд хэсэг орчимд амьтан хазсан, улмаар толгой өвдөх шинж тэмдэг илэрч, 3-р сарын 12-нд Аймгийн Нэгдсэн эмнэлэгт үзүүлсэн байна. Хачигт риккетсиозын онош тодруулахаар шинжилгээний материалыг (цусны ийлдэс, хачиг) дээжилж ЗӨСҮТ-д шинжилгээ хийхээр хүлээн аваад байна.

Монгол улсад:

Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол: Хэнтий аймаг

Хэнтий аймгийн Хэрлэн (2), Мөрөн (1) суманд галзуу өвчний эрсдэлд өртсөн 3 тохиолдол бүртгэгдсэн байна. Эрсдэлд өртсөн тохиолдлууд эмнэлэгт хандаж галзуугийн эсрэг вакцины эхний тунд хамрагдсан. Хэрлэн сумын 90 гаруй хүн амд галзуу өвчнөөс сэргийлэх сургалт хийсэн байна.

Эх сурвалж: Хэнтий ЗӨСТ

Галзуу өвчний мал, амьтны өвчлөл: Хэнтий аймаг

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Баянмөнх суманд галзуу өвчний мал, амьтны өвчлөл бүртгэгдэж, тус сумын засаг даргын захирамжаар 14 хоногийн хугацаатай хязгаарлалтын дэглэм тогтоосон байна. Голомтод байгаа 32 өрх айлын 90 хүнд сургалт хийж, галзуугийн эсрэг вакцинд 1 хүнийг хамруулжээ.

Эх сурвалж: Хэнтий ЗӨСТ

Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол: Хөвсгөл аймаг

Хөвсгөл аймгийн Хатгал суманд галзуу өвчний эрсдэлд өртсөн 1 тохиолдол бүртгэгдсэн байна. Эрсдэлд өртсөн тохиолдол галзуугийн эсрэг вакцины эхний тунд хамрагдсан тухай мэдээллээ.


Эх сурвалж: Хөвсгөл ЗӨСТ

ХОЁР. ТУХАЙН 7 ХОНОГТ БҮРТГЭГДСЭН ЗООНОЗЫН ШАЛТГААНТ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

Олон улсад:


Эбола вирус халдвар:

2019 оны 3-р сарын 07-ны өдрийн ДЭМБ-ын мэдээлснээр Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсад Эбола вирус халдварын сэжигтэй 907 тохиолдол (841 батлагдсан, 66 болзошгүй) бүртгэгдэж, үүнээс 569(63%) нь нас барсан тухай нийтэлсэн байна.



Зураг 1. Эбола вирус халдвар, Эпидемиологийн 7 хоногоор


Нийт тохиолдлын 514(57%) нь эмэгтэйчүүд, 273(30%) нь 18-аас доош насны хүүхдүүд тус тус эзэлж байна. Тус улсад тандалт судалгаа үргэлжилж байна.



Зураг 1. Эбола вирус халдвар, Бүгд Найрмдах Ардчилсан Конго улс

Сонгомол гахайн мялзан өвчин:

Япон улсын Хүнс хөдөө аж ахуйн яамны 2019 оны 3-р сарын 08-ны мэдээгээр Гифу мужийн Ямагата гахайн фермд Сонгомол гахайн мялзан өвчин бүртгэгдэж 8 гахай өвчилж, 1296 гахайг устгасан тухай ДАЭМБ-аас нийтэлжээ.



Эх сурвалж: ДАЭМБ

Шүлхий өвчин:


Марокко улсын Хөдөө аж ахуйн яамны 2019 оны 3-р сарын 08-ны мэдээгээр Соусс-Масса мужид “0” хэвшлийн вирусээр үүсгэгдсэн шүлхий өвчин бүртгэгдсэн. Нийт 3 үхэр, 2 ямаа, 13 хоньг устгасан тухай нийтэлжээ.



Эх сурвалж: ДАЭМБ

Хэл хөхрөх өвчин:


Египет улсын Мал амьтны эрүүл мэндийн газрын мэдээгээр 2019 оны 3-р сарын 11-ний өдөр Ал Вухайрах хотын үхрийн аж ахуйд малын хэл хөхрөх өвчний дэгдэлт бүртгэгдсэн байна. Нийт 484 үхэрнээс 35 үхэр үхсэн байна.



Эх сурвалж: ДАЭМБ

Шувууны томуу өвчин:


2019 оны 3-р сарын 14-нд БНХАУ-ын Хөдөө аж ахуй яамнаас мэдээлснээр Жанхуа хотод шувууны томуугийн H5N2 вируст халдварын дэгдэлт 3-р сарын 04-нд бүртгэгдсэн тухай ДАЭМБ-аас нийтэлжээ. Шувууны аж ахуйд нийт 800 шувууг устгаж, 33400 шувууг устгасан байна.



Эх сурвалж: ДАЭМБ

Тарваган тахлын хүний өвчлөлийн тохиолдол:

Уганда улсын Эрүүл мэндийн яамны мэдээгээр 2019 оны 3-р сарын 05-нд Зомбо дүүргээс тарваган тахлын хүний өвчлөлийн тохиолдол бүртгэгдэж, 35 настай, эмэгтэй нас барсан тухай нийтэлжээ. Мөн түүний 4 настай хүү хэд хоногийн өмнө нас барсан байна. Тандалт судалгаагаар энэ гэр бүл нь Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсын Итури мужийн Атунулей тосгонд амьдардаг байсан. Мөн БНАК улсын эрүүл мэндийн байгууллагууд Итури, Хойд Киву 2 мужид Эбола вируст халдварын дэгдэлт бүртгэгдэж, тандалт судалгаа үргэлжилж байгаа тухай нийтэлжээ.



Эх сурвалж: Promed

Энэ долоо хоногт үйл явдалд суурилсан тандалтын мэдээг Архангай(0), Баян-Өлгий(0), Дундговь(0), Хөвсгөл(0), Ховд(+), Хэнтий(+), Өмнөговь(0), Өвөрхангай(0), Увс(0), Завхан(0) аймгууд ирүүлсэн байна.